

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

V АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Шидэт цорго

Бат-Эрдэнэ хүү Буянт голдоо өдөржин сэлж, найзуудтайгаа тоглон наадна. Тэднийх хот руу нүүхээр болов. Хүү их л баяртай байлаа. Гэвч үеийн нөхөд, өрж тоглодог чулуугаа орхиод явна гэхэд нэг л гунигтай. Тоглоод л баймаар... “Миний хүү, ус аваад ир” гэж эмээг хэлэхэд хувингаа аваад гарлаа. Шанагаараа ус хутган, хувингаа дүүргэх агшинд Буянт гол “Баяртай” гэх шиг мяралзан урсана.

Улаанбаатарт ирлээ. Хотын амьдрал хөдөөгийнхөөс их л өөр. Олон хүн, машин тэрэг, өндөр байшин, өнгийн гэрэл... Хамгийн элбэг нь ус байв. Айл бүрийн ханан дахь цоргоноос ус под под дусална. Хэн ч тоохгүй байгаа нь гайхмаар. “Усаа хайрла. Ус чандмань эрдэнэ” гэсэн өвөө, эмээгийнхээ захиасыг айлын хүү Ганаад хэлсэн ч тоосонгүй. “Хайран ус” гээд Бат- Эрдэнийг ухасхийгээд бүгд шоолон инээлдэнэ. Ус нь ширгэхгүй бас дуусахгүй байхыг бодоход энэ лав шидэт цорго байх аа. Бат-Эрдэнэ хүү ингэж бодоод аавдаа хэлэв.

-Шидэт цоргоноос хөдөө явуулъя, тэгэх үү?

-Яагаад шидтэй гэж?

-Ус нь дуусдаггүй юм чинь.

-Дуусдаггүй юм гэж үгүй. Харин хайрлаж гамнах л хэрэгтэй гэж аав нь хэлэв.

Бат-Эрдэнэд нэг санаа төрлөө.дусалж байгаа усыг саванд тосохоор болов. Ганаа түүнийг ажиглаад: “Цорго нь эвдэрсэн юм чинь дуслалд л байна шүү дээ” гэж хэвнэг хэлэв. Бат-Эрдэнэ үүнийг сонсоод “Тэгвэл цоргыг нь засчихъя, тэгэх үү” гээд хоёулаа ажлаа эхлэв. Бат-Эрдэнэ, Ганаагаас чи ус уухгүй хэр удаан байж чадах вэ? гэж асуухад бараг 5 цаг ч болохгүй ээ гэж хариулав. Бат-Эрдэнэ Ганаад бид усаа хайрлан хамгаалахгүй бол “Усгүй дэлхий” болох аюулд орж болзошгүй байгаа талаар өвөөгийн ярьсныг ярьж өглөө. Ганаа Бат – Эрдэнийг анхааралтай сонсож, усаа хайр гамгүй ашиглаж байсандаа өөрийгөө буруутгаж бодлоо.

1. Дусалж байгаа усыг саванд тосох болсны учрыг эхийн эхлэл хэсгээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

2. А. Эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? /1 оноо/

.....

- Б. Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

3. А. Бат-Эрдэнэ хүүгийн хийсэн үйл, хэлсэн үгийг ялган бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

.....

- Б. Бат-Эрдэнэ хүүгийн хийсэн үйл, хэлсэн үгэнд үндэслэн зан чанарыг тодорхойлж бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

.....

4. Хүснэгтэд Ганаагийн зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй. **/3 оноо/**

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>Яагаад өөрчлөгдөх болсон бэ?</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	

5. Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж бичээд, яагаад өгүүлбэрийг сонгосноо өөрийн үгээр тайлбарлана уу. **/3 оноо/**

.....

.....

.....

.....

6. “Дурсамж дүүрэн 9-р сарын 1” сэдвээр өөрт тохиолдсон явдлаа 100-120 үгэнд багтаан бичээрэй.

Бичихдээ:

- Эхлэлт хэсэгт – Үйл явдал өрнөсөн орчныг дүрслэн бичээрэй.
- Гол хэсэг – Өөрт тохиолдсон, болсон явдлыг бичих
- Төгсгөл хэсэгт – Өөрт тохиолдсон явдлаар дамжуулан бусдад ямар сургамжит санаа өгч болох вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Lined writing area consisting of multiple horizontal dotted lines.